



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/335

Мөрөн сум

Захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй  
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.7, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газрын 2022 оны 71/A2260435 дугаартай албан шаардлагаар Мөрөн сумын 2020 оны тухайн жилийн газар зорион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байршил болох "Мөрөн сумын 14 дүгээр багт Германы сургалт мэдээллийн төвийн зүүн талд "Инфюшин" ХХК-д амины орон сууцны зориулалтаар 2 га газрыг эзэмшүүлэх"-ээр шийдвэрлэсэн нь Газрын тухай хууль тогтоомжийг зөрчсөн болох нь тогтоогдсон тул Мөрөн сумын Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/190 шийдвэрийн 6 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

2. Дээрх захирамжийн дагуу Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сангаас хасалт хийж, захирамжийг холбогдох этгээдэд танилцуулах ажлыг шуурхай зохион байгуулж, баримтыг бүрдүүлэн ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийг эс зөвшөөрвөл захирамж гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус даалгасугай.

ДАРГА



ШИДЭРБАЯСГАЛАН